



**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 07-р сарын 29-ний өдөр

Дугаар: ТУЗ-26/26

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Инновэйшн инвестмент" ХК (цаашид "Компани" гэх) ийн Дүрмийн 23 дугаар зүйл, 23.1 дэх заалт болон "Ногдол ашгийн бодлого"-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн хуримтлагдсан ашгаас нийт эргэлтэнд гарсан 184,889,160 (нэг зуун наян дөрвөн сая найман зуун наян есөн мянга нэг зуун жаран) ширхэг энгийн хувьцаанд нийт 11,093,349,600 (Арван нэгэн тэрбум ерэн гурван сая гурван зуун дөчин есөн мянга зургаан зуун) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 60 төгрөгөөр тогтоосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөр тогтоосугай.

4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар, хуулийн этгээдийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан 2026 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох шийдвэрийг хүргэх болон ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулж энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б. Энхболд/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Х.ДОРЖСҮРЭН